



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар Д/328

Хэрлэн сум

Уулзалт зохион байгуулах байрны
зардалд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод сумын Засаг дарга нартай хийх уулзалт зохион байгуулахад шаардагдах байрны түрээсийн зардалд 400.000 (дөрвөн зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ